

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

БИЧЛЭГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: “дөрөв дэх засаглал”, “залхуу сэтгүүл зүй”, уруугаа харсан пирамид, мэдээллийн багтаамж, ярилцлага-сурталчилгаа.

Монголын сэтгүүл зүйн үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, шинэчлэлийн асуудлыг судлахдаа ОНМХ-ийн системд гарсан өөрчлөлт, нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад гарсан өөрчлөлт, сэтгүүлчийн ур чадвар, бичлэгийн төрөл зүйлд гарсан өөрчлөлт хэмээх үндсэн дөрвөн хүрээнд авч үзэх нь онол, арга зүй, практикийн хувьд чухал ач холбогдолтой юм. ОНМХ-ийн систем, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга болон сэтгүүлчийн ур чадварт гарсан өөрчлөлтийн асуудлыг өмнө нь хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдэд тусгайлан авч үзсэн учраас энд зөвхөн төрөл зүйлд гарсан өөрчлөлт, эерэг ба сөрөг хандлагуудын талаар тогтож ярихыг зорилго болголоо.

Ерээд оноос хойш Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлд гарсан өөрчлөлт, шинэчлэлийн талаар ярихаас өмнө манай сэтгүүлчдийн дунд нэлээд өргөн дэлгэрсэн нэгэн зүйлийн тухай

товч дурдах хэрэгтэй юм. Зарим уран бүтээлчийн дунд чөлөөт сэтгүүл зүйд бичлэгийн төрөл, зүйл хэмээх ойлголт байдаггүй, хэн яаж бичих нь зохиогчийн эрх, хамгийн гол нь агуулга, хүлээн авагчдад өгч буй үр өгөөж нь чухал гэж үздэг хандлага өргөн дэлгэрчээ. Өөр нэг хэсэг нь бичлэгийн төрөл зүйл байхад илүүдэхгүй, үгүй бол дутах юмгүй гэж үздэг бол гурав дахь хэсэг нь бичлэгийн төрөл, зүйл байх ёстой гэсэн үзэл бодлыг хатуу барьдаг. Өнгөцхөн харахад дээрх үзэл бодлын аль алиныг хүлээн зөвшөөрч болох талтай. Гэхдээ аливаа агуулга тодорхой нэг хэлбэрт оршдог бөгөөд философийн шинжлэх ухааны үүднээс хандвал агуулгагүй хэлбэр, хэлбэргүй агуулга орших ёсгүй юм. Өргөн утгаар нь авч үзвэл бичлэгийн төрөл, зүйл гэдэг бол сэтгүүлчдийн бичиж, бэлтгэж ОНМХ-үүдээр олон нийтэд түгээж буй нийтлэл, нэвтрүүлгийн тодорхой нэг хэлбэр байдаг. Тэгвэл ОНМХ-ээр дамжуулж буй аливаа материал тодорхой нэг хэлбэрээр оршдог нь зүйн хэрэг бөгөөд тухайн зохиогчийн авьяас чадвар, өмнөө тавьсан зорилго, тусгаж буй объектийн мөн чанараас шалтгаалан янз

бүрийн хэлбэрт оршдог нь тодорхой юм. Нөгөө талаар уншигчдад тухайн нэвтрүүлгийг ямар аргаар, ямар хэлбэрээр яаж өгөх вэ гэдгээс түүний үр нөлөө, үр ашиг ихээхэн шалтгаалах болсон. Үүнд хүлээн авагчдын боловсрол, мэргэжил, бүтэц бүрэлдэхүүн, нас, хүйс, оршин суугаа орчин зэрэг маш олон хүчин зүйл бас нөлөөлдөг. Тиймээс дээрх хүчин зүйлсээс шалтгаалан нийтлэл, нэвтрүүлгийн хэлбэр байнга баяжиж, гүнзгийрч байдаг нь зүйн хэрэг. Харин тэр хэлбэр хэзээ ч устаж үгүй болох учиргүй. Үүнээс үзвэл чөлөөт сэтгүүл зүйд бичлэгийн төрөл, зүйл байдаггүй гэдэг нь үндсээр нь буруу, ямар ч үндэслэлгүй ойлголт юм. Харин нийтлэлийн хэлбэрийг яаж нэрлэх нь чухал биш бөгөөд дэлхийн зарим оронд бичлэгийн төрөл, зүйлийн нэр томъёоны хувьд зөрүүтэй зүйл цөөнгүй байдаг. Тухайлбал, Баруун Европ болон Америкт бидний нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөл, зүйл гэж нэрлэдэг зүйлүүдийн ихэнхийг эссе гэж нэрлэдэг, манай урд хөрш, түүний дотор ӨМӨЗО-д сурвалжлагыг чимээлэл, ярилцлагыг сурвалжлага гэж нэрлэдэг жишээтэй. Хөрөг, аян замын тэмдэглэл, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, мэдээ, шүүмж, тойм, редакцийн өгүүлэл зэрэг нэр томъёо ихэнх оронд нийтлэг юм.

Орчин үед чөлөөт сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудын сонин хэвлэлд 20 гаруй бичлэгийн төрөл, зүйл тогтмол гардаг байна. Энэ бүхэн нь сэтгүүл зүйн мэргэжлийн асуудалд дур зоргоороо хандаж, туйлын эрх чөлөөг эдлэх гэсэн, бас мэдлэг, чадвар нь дутахаар есөн шидийн шалтаг тоочдог хагас дутуу боловсорсон хүмүүсийн “дүгнэлт” ямар ч үндэслэлгүй болохын тод жишээ мөн.

Өнөөдөр тийм боловсон хүчин хэт олширноос манай сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл хэт явцуурч, улиг болсон хэдэн бичлэнгийн төрлийн хүрээнд эргэлддэг болсныг хүлээн авагчид зүй ёсоор шүүмжилдэг болсон билээ. Энэ бол үндэслэлтэй шүүмжлэл бөгөөд бичлэгийн төрөл, зүйлд ингэж янз бүрийн үзэл бодлоор хандаж буй нь сэтгүүлчдийн ур чадварт сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнтэй холбогдуулан Армянны нэрт сэтгүүлч, одоо Английн BBC-д ажиллаж буй Марк Григорян: “Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл, нөөц боломж шавхагдашгүй баян юм. Гэхдээ зураач харандаагаар, нүүрсээр зурж чадах, янз бүрийн өнгө будаг, гадаргуудын шинж чанар, төлөв байдал, хуулиудыг мэдэх шаардлагатайн нэгэн адил тэднийг оновчтой, үр өгөөжтэй ашиглаж чадах хэрэгтэй”¹ гэж бичсэнийг онцлон тэмдэглэвэл зохино. Энэ бол сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийн ач холбогдол, үнэ цэнийг туйлын оновчтой үнэлсэн хэрэг юм.

Бичлэгийн төрлүүд эрс багасч, мэдээ, ярилцлага, эргэцүүлэл зэрэг цөөхөн хэдэн бичлэгийн төрлийн хүрээнд эргэлдэх болов. Тодруулж хэлбэл хэмжээний хувьд бага байвал мэдээ, асуулт хариултаас бүрдсэн бол ярилцлага, бүх бичлэгийн төрөл, зүйлүүдийг хольж хутгасан бол эргэцүүлэл гэж нэрлэх болсон нь сонин хэвлэлд нэг хэвийн ижил төстэй бичлэгийн өнгө аяс давамгайлахад хүргэсэн юм. Үүний гол шалтгаан нь нэг талаар богино хугацаанд сонин хэвлэлийн тоо хэт олширч, сэтгүүл зүйн салбарт мэргэжлийн бус хүмүүс хэт их хэмжээгээр орж ирсэнтэй, нөгөө талаар хэвлэл

мэдээллийн ажилтнууд мэдээллийн шуурхай байдал хэмээх далбаан дор өөрсдийн ажлыг хэт хөнгөвчилж, сэтгэлгээ, хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг төрөл, зүйлүүдээс зайлсхийдэг, тойрч өнгөрдөг хандлага газар авсантай холбоотой юм. Үүнд нэрмээс болж буй өөр нэг хүчин зүйл бол гадаадын ганц нэг оронд очоод хагас дутуу боловсорсон зарим хүн сэтгүүл зүйд дөнгөж хөл тавьсан залуу уран бүтээлчдэд Баруунд төрөл зүйл хэмээх ойлголт байдаггүй, хэн яаж бичих нь тухайн сэтгүүлчийн хэрэг, хэлбэр гол биш, агуулга нь чухал гэсэн буруу зөрүү ойлголт өгч, тархийг угааж байгаа явдал юм. Энэ бол үндсээр нь буруу ташаа ойлголт бөгөөд өнөөдөр Барууны чөлөөт сэтгүүл зүй сайн хөгжсөн орнуудад наад зах нь 18-20 төрөл, зүйлийг өргөн ашиглаж байна².

Сэтгүүлчид харьцангуй их хүч хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг, ухаан зардаг шинжлэлт болон нийтлэл-уран сайхны бичлэгийн төрлүүдийг барьж авахаас халширдаг болсноос улиг болсон цөөхөн хэдэн бичлэгийн төрлийн хүрээнд эргэлдэж, тэднийг хэвшмэл арга барил, өнгө аясаар бичих явдал түгээмэл байна. Тулга тойрсон хэдэн асуулт, улиг болсон хэвшмэл хэдэн өгүүлбэр, идэвхгүй үг хэллэг, ямар ч шаардлагагүй сул үг, нэг хэв загварт цутгасан юм шиг уйтгартай, үр өгөөж муутай саарал нийтлэлийг үйлдвэрлэхэд хүргэж байгаа нь манай сэтгүүл зүйн өнөөгийн дүр төрхийг харуулах нийтлэг шинж юм. Энэ бол манай сэтгүүлчдэд эрэл хайгуул, идэвх чармайлт, бас аливаа үзэгдэл, баримтын цаад мөн чанарт нэвтрэх, шинэ зүйлийг мэдрэх чадвар, мэргэжлийн болон

ерөнхий суурь мэдлэг дутаж байгаагийн бодит илрэл мөн. Ер нь манай залуу сэтгүүлчдэд бусдын бүтээлийг унших, түүнээс бүтээлчээр суралцах, алдаа дутагдлаа засаж залруулах гэсэн хүсэл эрмэлзэл туйлын хангалтгүй байгаа нь нийтлэг шинжтэй болжээ. Манай сэтгүүл зүйн практикт Барууны сэтгүүл зүйд түгээмэл хэрэглэгддэг бичлэгийн зарим арга барил, өнгө аяс нэвтэрч эхэлж байгаа боловч, тийм ч идэвхтэй, үр нөлөөтэй биш байна. Тухайлбал, манай ХМХ-үүдэд гарч буй мэдээ, ярилцлага, тэдний лид Барууны сэтгүүл зүйгээс ихээхэн ялгаатай байгаа нь ажиглагддаг. Барууны сэтгүүл зүйд гол төлөв ямар нэгэн асуудал, үйл явдлын учрыг тайлах, энэ талаарх ярилцагчийн санал бодлыг мэдэх зорилгоор хийсэн нүүр тулсан ярилцлага (tat-a-tat) байдаг бол манай ярилцлагын ихэнх нь ярилцагчийн үйл ажиллагаа, намтар түүхийг тусгасан ярилцлага-танилцуулга, ярилцлага-сурталчилгаа, ярилцлага-үйл ажиллагаа байдаг онцлогтой.

Барууны сэтгүүл зүйд хүний ажил, намтрыг тусгасан, хэвлэлийн бага хурлын мэдээ баримтыг ашигласан бүтээлүүдийг *Lazy journalism* буюу "залхуу сэтгүүл зүй" гэж нэрлэдэг. Өнөөдөр Монголын сэтгүүл зүйд хэдийгээр ахиц өөрчлөлт байгаа боловч энэхүү "залхуу сэтгүүл зүй"-н шинж байсаар байна. Мөн сүүлийн үед сурвалжлагаар эхлээд ярилцлагаар төгссөн, эсвэл ярилцлагаар эхлээд эргэцүүлээр дууссан "холимог ярилцлага" дэлгэрэх шинжтэй байгаа нь ярилцлагын ур чадварыг сайжруулах биш, улам сул, үлбэгэр болоход нөлөөлж байна. Мэдээ гэхэд эхлээд эх сурвалжийн мэдээллээс авсан ишлэл,

дараа нь тухайн эх сурвалжийг танилцуулсан, үйл явдлын талаар өгүүлсэн, төгсгөлд нь үйл явдлын өмнөх түүхийг товч дурдсан бүтэцтэй байдаг нь түгээмэл юм. Бас л хүний хэлсэн үгийн агуулгыг, эсвэл үгийг иш татах маягаар лид болгосон, сонирхолгүй, уйтгартай, нэг хэв загварт баригдсан байдаг. Хэрэв мэдээний сонгодог хэлбэр нь 5W&H-ийг хэн, юу, хаана, хэзээ, яагаад, яаж гэсэн дарааллаар бичигддэг бол манай мэдээнүүд хэн (хэлсэн), юу, хэнд, хэзээ, хаана гэсэн дарааллаар бичигдсэн, яагаад, яаж гэсэн асуултанд огт хариулаагүй орхисон байдаг. Тиймээс энгийн боловч анхаарал татах зүйлгүй, хөтөчгүй, сонирхолгүй болдог. Үүнээс үзэхэд манайд сонгодог утгаараа лид

байхгүй гэж хэлж болно. Өгүүлэл маягийн бичлэгийн томоохон төрөл, зүйлүүдийн хувьд "ерөнхийгөөс нэгж рүү" шилжих аргаар бичих хандлага давамгайлсан хэвээр байна. Эхлээд асуудлаа томъёолдог, ерөнхий нөхцөл байдлыг тусгадаг, дараа нь жишээ баримтаар үүнийг нотлох гээд оролддог. Ихэнх тохиолдолд энэ нь нийтлэлийг нуршуу, гол зүйлд орохын тулд баахан түүх намтар өгүүлсэн, хэрэгтэй хэрэггүй юм тоочиж үндсэн асуудлыг бүрхэгдүүлсэн, дотоод логик холбоо нь зөрчигдсөн, мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдол тааруу, зохиогчийн үзэл бодол давамгайлсан шинжтэй болгодог. Өнөөдөр манай томоохон сонин хэвлэлд

нийтлэгдэж байгаа асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт нийтлэлийн ихэнх нь ийм маягаар бичигдсэнийг амархан ажиглаж болно. Үүнийг Барууны сэтгүүл зүйд хатуу хориглодог бөгөөд "нэгжээс ерөнхий рүү орох" аргаар бичихийг чухалчилдаг. Энэ нь гол зүйлээ шууд хэлсэн, хүлээж авахад амар хялбар, энгийн ойлгомжтой, товч тодорхой болоход нөлөөлдөг байна. Манай сэтгүүл зүйн бичлэгт оршиж буй ийм дутагдал бол сэтгүүлчдийн ур чадвар, бичлэгийн арга барил нэлээд удаан шинэчлэгдэж, бас шинэ сэргэг зүйлийг хүлээж авах тал дээр идэвх санаачилгагүй ажиллаж буйн илрэл юм. Бичлэгийн төрөл, зүйл багасахад нөлөөлж буй өөр нэг шалтгаан бол мэ-

«

Манай үе үеийн нэрт сэтгүүлч, уран бүтээлчдийн янз бүрийн төрөл, зүйлээр бичигдсэн шилдэг нийтлэлүүдийг уншихгүйгээр, тэдний бичлэгийн арга барилаас бүтээлчээр суралцахгүйгээр сайн сэтгүүлч болох, янз бүрийн төрөл зүйлээр бичих боломжгүй гэдэг нь практикаар батлагдсан зүйл.

»

дээж сэтгүүл зүйн сургалттай, тухайн уран бүтээлчийн идэвх чармайлт, бие дааж өөрийгөө хөгжүүлэх чадвартай холбоотой гэдэг нь ойлгомжтой. Манай үе үеийн нэрт сэтгүүлч, уран бүтээлчдийн янз бүрийн төрөл, зүйлээр бичигдсэн шилдэг нийтлэлүүдийг уншихгүйгээр, тэдний бичлэгийн арга барилаас бүтээлчээр суралцахгүйгээр сайн сэтгүүлч болох, янз бүрийн төрөл зүйлээр бичих боломжгүй гэдэг нь практикаар батлагдсан зүйл. Мөн энд танхимын сургалт буюу сэтгүүл зүйн онолын мэдлэг чухал байхаас гадна сэтгүүлчийн идэвхтэй эрэл хайгуул, хөдөлмөрч чанар, бусдаас суралцах чин хүсэл эрмэлзэл онцгой үүрэг гүйцэтгэх болно.

Сэтгүүл зүйн мэдээлэх үүргийн ач холбогдол нэмэгдэж, мэдээллийн шуурхай чанар дээшилж байгаатай холбоотой мэдээллийн бичлэгийн төрөл, зүйл бүхэлдээ нэмэгдэж ямар ч сонин хэвлэлд гол байр эзлэх болсон. Энэ бол ганц манай сэтгүүл зүйд бус социализмын дараах бараг бүх оронд ажиглагдаж буй нийтлэг үзэгдэл бөгөөд орчин үеийн дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийн нэг хандлага гэж хэлж болно. Өнөөдөр манай радио, телевиз, өдөр тутмын сонинуудад мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг гол байр эзэлж байна. Тухайлбал, телевизүүд оройн мэдээллийн хөтөлбөрөөс гадна сондгой цаг болгонд мэдээ нэвтрүүлж, өдөр тутмын томоохон сонинуудын нийт материалын 25-40 хүртэлх хувийг мэдээ, мэдээллийн шинжтэй зүйл эзлэх болсон нь үүний нэг тод жишээ мөн. Гэхдээ манай ХМХ-үүдэд оршиж буй гол дутагдал бол мэдээллийн бичлэгийн төрөл, зүйлүүдийг, тэдний дотоод хэлбэрүүдийг бүрэн ашиглаж чадахгүй, мэдээ, ярилцлага зэрэг 2-3 төрлийн хүрээнд эргэлдэх явдал юм. Энэ бол манай сонин хэвлэлүүд бичлэгийн арга барил, нөөц боломжоо бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байгаагийн нэг илрэл гэж хэлж болно.

Бүх бичлэгийн төрлүүд хэмжээний хувьд багасах хандлага ажиглагдаж байна. Энэ бол нэг талаар дэлхий дахинд сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж, мэдээллийн багтаамж, шуурхай байдлыг дээшлүүлэх шаардлага хурцаар тавигдаж байгаатай, нөгөө талаар манай сэтгүүлчид ур чадвар шаарддаг томоохон хэмжээний асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт болон хошин шог төрлийн материал бичихээс халширдаг болсонтой холбоотой. Танин мэдэхүйн ач холбогдол

өндөр, хүлээн авагчдын сэтгэл зүйд нөлөөлж чадахуйц, агуулга хэлбэрийн өндөр төвшинд бичигдсэн чанартай сайн материал бичихээсээ илүү хов живийн, дуулиан шуугианы шинжтэй материал бичихийг чухалчилдаг нь түгээмэл юм. Нөгөө талаар энэ нь олон нийтийн сэтгэл зүйгээр тоглох замаар сониноо борлуулах гэсэн редакцийн бодлоготой ч холбоотой.

Нийтлэл-уран сайхны, түүний дотор хошин шог бичлэгийн төрлүүд эрс багассан. Энэ бол үндсэндээ нийгэмд гарсан өөрчлөлт, чөлөөт хэвлэлийн чиг үүрэг, хөгжлийн хандлагатай холбоотой юм. Захиргаадалтын болон магтаалын өнгө аяс нэвт шингэсэн, уриалан дуудсан, удирдан чиглүүлсэн, хэвшмэл хэлбэрт баригдсан, хэрэгтэй хэрэггүй юмыг тоочин нуршсан, уянгын халилд хэт автагдсан бичлэгийн арга барил цаг үеийн өөрчлөлтийг дагаад алга болохоос өөр аргагүй болсон. Ялангуяа найруулал, улс төрийн шог, шог найруулал, уран нийтлэл, сурвалжилсан тэмдэглэл зэрэг төрлүүд өдрийн од шиг ховор үзэгдэх болов. Энд нэг зүйлийг онцлон хэлэхэд зарим бичлэгийн зүйлийн талаар сэтгүүлчдийн дунд ч, уншигчдын дунд ч удаан жилийн турш буруу ойлголт газар авсан нь дээрх бичлэгийн төрлүүд багасахад хүчтэй нөлөөлсөн явдал юм. Өөрөөр хэлбэл, найруулал заавал хүнийг магтах ёстой, шог найруулал заавал муулах ёстой, улс төрийн шог заавал улс төр-үзэл суртлын тэмцлийг тусгах ёстой, уран нийтлэл заавал бусдыг уриалан дуудах ёстой юм шиг ойлгож, бичиж ирснээс болж чөлөөт сэтгүүл зүйд дээрх бичлэгийн төрлүүд байх ёсгүй юм шиг үздэг хандлага бий

болсон. Энэ бол тухайн үеийн нийгмийн онцлогтой холбоотой болохоос биш бичлэгийн төрлийн уг мөн чанартай огт хамаагүй асуудал юм. Дээрх бичлэгийн төрөл, зүйлүүдийг нийгмийн өнөөгийн шаардлагын үүднээс арга барил, дотоод хэлбэрийн хувьд баяжуулан хөгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд өнөөдөр манай сэтгүүлч, уран бүтээлчид үүнийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт нийтлэлийн тоо нэмэгдсэн. Энэ бол нэг талаар ил тод байдал, олон ургальч үзлийн үед олон жилийн турш хаалттай байсан хориотой бүсэд чөлөөтэй нэвтрэх боломжтой болж, батлан хамгаалах систем, хууль хяналтын байгууллагын болон удирдах дээд байгууллагуудын үйл ажиллагаа, хорих газруудын амьдрал ахуй, өндөр албан тушаалтнуудын хариуцлага, ёс суртахууны асуудал, түүхийн "цагаан толбо", Монгол-Зөвлөлтийн найрамдал нөхөрлөлийн сүүдэртэй тал, байгаль экологийн сэдэв, гадаадын зээл тусламж, гэрээ хэлэлцээр, банк санхүүгийн үйл ажиллагаанд оршиж буй хууль бус үйл ажиллагаа зэрэг урьд өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэр болгон ярьж, бичдэггүй сэдэв рүү түлхүү хандаж, өөрсдийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж нэмэгдсэнтэй, нөгөө талаар аливаа асуудалд шүүмжлэлтэй хандаж, дутагдал доголдлыг илчлэн шүүмжилж, үнэлэлт дүгнэлт өгч, шийдвэрлэх арга замыг эрж хайх хандлага ганцхан нийтлэл, нэвтрүүлэгт төдийгүй газар сайгүй хүчтэй өрнөсөнтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл, ардчилсан нийгмийн нэг чухал шинж болох олон ургальч үзэл, ил тод байдал, хүмүүсийн үг хэлэх, үзэл

бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх боломж хэвийн үзэгдэл болсны тод илэрхийлэл гэж хэлж болно. Энэ бол чөлөөт хэвлэлийн нэг чухал үүрэг болох хяналт тавих үүргийг хэрэгжүүлэх, "дөрөв дэх засаглал"-ын төвшинд хүрч ажиллахад шууд нөлөөлөх сайн талтай юм. Гэхдээ чанар, үр нөлөө, үр чадварын хувьд ерээд оноос өмнө гарч байсан асуудал дэвшүүлсэн өгүүллийн төвшинд хүрсэн нийтлэл нэн ховордож, харин асуудал дэвшүүлсэн өгүүлэл, сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, тэмдэглэл зэрэг хэд хэдэн бичлэгийн төрөл, зүйлийн шинжийг агуулсан, асуудал дэвшүүлэх, эргэцүүлэн бодох, шүүмж-лэлтэй хандах зорилго бүхий эргэцүүлэл маягийн нийтлэл олшрох хандлагатай байна.

Асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт нийтлэл тооны хувьд нэмэгдэж байгаа нь сайн боловч чанар, үр чадварын хувьд шаардлагын төвшинд хүрэхгүй байгаагаас олон нийтийн анхаарлын гадуур үлдэх, сэтгэл зүйд тодорхой нөлөө үзүүлж чадахгүй байх зэргээс шалтгаалан үр өгөөжгүй өнгөрөх явдал түгээмэл ажиглагдах болсон. Нөгөө талаар сэтгүүлчид сонгож авсан сэдвийг дутуу дулимаг судлах, хоёрдогч эх сурвалжаар баталгаажуулах, оновчтой бүтэц зохиомжид оруулан боловсруулах, ухаан зарж хөдөлмөр гаргах талаар хангалтгүй ажиллаж буй нь ийм чанаргүй бүтээгдэхүүн гарах гол шалтгаан болж байна.

Сүүлийн жилүүдэд бичлэгийн төрөл, зүйлийн хөгжилд ажиглагдаж буй хандлага бол бичлэгийн төрлүүд хоорондоо уусах, нэгдэн нийлэх, холимог шинжтэй болох явдал юм. Ялангуяа өөрийгөө чөлөөт хэвлэл гэж нэрлэж буй зарим

сонин хэвлэлд ийм хандлага нэлээд эрчимтэй явагдаж байгаа бөгөөд бичлэгийн төрөл зүйлийн асуудлыг хоёрдугаар байранд тавих, хайнга хандах, түүнд тавих шаардлага эрс суларснаас бичлэгийн нэг л өнгө аяс давамгайлсан, уйтгартай, өгөөж муутай, хэвшмэл хэв загварт баригдсан нийтлэл хэт олширсон. Тиймээс бидний дээр дурдсан мэдээ, ярилцлага, өгүүлэл (үүнийг гол төлөв эргэцүүлэл гэж нэрлэдэг болсон) зэрэг цөөхөн хэдэн бичлэгийн төрөл, зүйлийн хүрээнд эргэлдэх болсон.

Тогтмол хэвлэлийн гол бичлэгийн нэг болох өгүүлэл өнөөдөр цэврээрээ оршин тогтнохоо больж, олон бичлэгийн төрөл зүйлийн шинжийг нэгэн зэрэг агуулж, тэдний зааг дээр оршдог болжээ. Өгүүлээс мэдээлэл, шүүмжлэл, дүн шинжилгээ, эргэцүүлэл, ярилцлага, үнэлэлт дүгнэлт, хувь хүний сэтгэгдэл, тэр ч байтугай уянгын халилыг ч амархан олж болно. Ийм бичлэгийн олон зүйлийн шинжийг агуулдаг болсон учир өгүүлэлд "эргэцүүлэл" хэмээх ерөнхий бөгөөд бөөрөнхий нэр оноогоод удаж байна. Үүнийг манай зарим туршлагатай сэтгүүлч хүртэл ихээхэн дэмжиж, бараг нээлт шахам зүйл гэж ярьж явдаг нь гайхал төрүүлдэг. Угтаа бол эргэцүүлэл гэдэг нь өгүүлэл болж чадаагүй, асуудал дэвшүүлэх, эсвэл шүүмжлэх гээд бүх юмыг хольж хутгасан зохиогчийн хувийн тэмдэглэл маягийн зүйл юм. Аливаа бичлэгийн төрөл зүйлийн цаана сэтгүүлчийн ур чадвар байдаг нь тодорхой. Тэгвэл бичлэгийн төрөл зүйл бага байна гэдэг бол логик утгаараа тухайн редакцийн сэтгүүлчдийн бичлэгийн ур чадвар туйлын хангалтгүй байна

гэсэн үг юм. Бичлэгийн тодорхой нэг төрөл, зүйлээр мэргэшсэн туршлагатай сэтгүүлчид төрөл, зүйлд тавигдах шаардлагын төвшинд бичдэг боловч тэд тун цөөн байна. Бас нөлөө бүхий томоохон сонин хэвлэлийн эрхлэгчид ч энэ асуудалд хэт хайнга ханддаг тал бий. Энэ бүхэн нь манай сонин, сэтгүүлүүд мэдээллийн бичлэгийн цөөхөн хэдэн төрөл, зүйлийн хүрээнд эргэлдэж, сэтгүүлчид хүч хөдөлмөр, цаг хугацаа, авьяас чадвар шаарддаг төрөл зүйлийг тойрч явдаг буруу хандлага газар авах шинжтэй болжээ.

Энэ бол сэтгүүлч уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлүүдийн нэг мөн. Сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэн "Өнгөрсөн зууны ерээд оноос хойш Монголын сэтгүүл зүйд найруулал хэмээх төрөл зүйл байхгүй болсон, энэ жанраар бичих шаардлагагүй гэж ярьж хэлж мэдэмхийрэгчид олширчээ. Найруулал цөөрсөн нь үнэн. Сонин, сэтгүүлийн хуудаснаа бараг үзэгдэхгүй байна. Гэхдээ сэтгүүл зүйн төрөл зүйлийн хувьд устан үгүй болсон гэдэг нь юу л бол. Миний санахад их нийтлэлч Бямбын Ринчен лугаа адил ур чадвар зааж найруулал бичигч нь харин илэрхий цөөрсөн юм бишүү гэж хэлмээр байна"³ гэсэнтэй санал нэг байна. Гэхдээ энэ бол нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөл зүйл цөөрөхөд нөлөөлсөн ердөө нэг л шалтгаан. Б.Ринчен шиг авьяаслаг зохиолч, сэтгүүлч социализмын үед ч цөөн байсан. Одоо бүр нүдний гэм болсон. Асуудлын гол нь сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргагчдын бичлэгийн төрөл, зүйл хэмээх сэтгүүл зүйн чухал ойлголтод

хандах хандлага нь эрс өөрчлөгдсөнтэй холбоотой. Нөгөө талаар ХМХ-үүдийн хооронд өрсөлдөөн бий болж, мэдээллийн шуурхай чанар эрс дээшилж, мэдээлэх үүргийн ач холбогдол нэмэгдсэн нь авьяас, хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг, хэмжээний хувьд том, шуугиан дэгдээж олон нийтийн сэтгэл зүйд шууд нөлөөлөх зорилгоор бичигдсэн чанартай нийтлэл цөөрөхөд хүргэсэн. Өөрөөр хэлбэл, энэ хандлагыг ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийг мэдээлэл гэхээсээ илүү таваар, бизнес гэж үздэг болсонтой холбон тайлбарлаж болно.

Зарим бичлэгийн төрөл устаж үгүй болж, зарим бичлэгийн төрөл, зүйл болон тэдний дотоод хэлбэрүүд баяжиж, шинээр бий болох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, тэргүүн өгүүлэл, дагавар өгүүлэл устаж үгүй болоод улс төрийн шог, шог найруулал, тойм, хэвлэлийн тойм, үйл явдлын болон асуудал дэвшүүлсэн найруулал эрс цөөрч, шинжлэх-ухаан танин мэдэхүйн эссе, редакцийн өгүүлэл, асуудал дэвшүүлсэн, хөрөг-ярилцлага, өөрөө өөртэй хийсэн болон эчнээ ярилцлага, эргэцүүлэл, тайлбар-тэмдэглэл, үзэл бодлын өгүүлэл, номын мэдээ зэрэг бичлэгийн зүйл, хэлбэрүүд эрчимтэй нэвтэрч эхэлсэн. Мөн хүлээн авагчдад нэмэлт мэдээлэл өгөх, зугаацуулах зорилго бүхий нөхөрсөг шог, наргиа, явган шог, үлгэр, сонжоо, зөвлөгөө, тодруулга, элэглэл, үгийн сүлжээ, хууч яриа зэрэг туслах бичлэгийн зүйлүүд (зарим бүтээлд бичлэгийн жижиг зүйл гэж нэрлэсэн байдаг) нэмэгдсэн. Үүнийг сэтгүүл зүй судлаач, доктор Л.Норовсүрэн “Иймэрхүү зүйлүүдийн шинжийг нэгтгэсэн нэгэн зугаатай

бичлэгийг “онигоо” гэсэн нэрээр ерээд оны сонинууд ихээхэн нийтэлж, тэдгээрийг эмхэтгэсэн ном товхимол ч олон гарсан нь содон үзэгдлийн нэг байв”⁴ гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Энэ бол зүй ёсны үзэгдэл бөгөөд цаашид ч нэлээд идэвхтэй явагдах болно. Учир нь бичлэгийн төрөл аливаа уран бүтээлчийн авьяас чадвараас шууд шалтгаалдаг бөгөөд сэтгүүлчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, дадлага туршлага, идэвх санаачилга, эрэл хайгуул нь нэмэгдэх тусам бичлэгийн төрөл, зүйл, хэлбэрүүд улам баяжин гүнзгийрч, шинээр үүсэн бий болж, нийгмийн хөгжил, цаг үеийн шаардлагыг даган зарим нь устаж алга болох жамтай юм. Нөгөө талаар, орчин үед сэтгүүл зүйн гедонист буюу зугаацуулах үүргийн ач холбогдол эрс нэмэгдэж байгаагийн дээр бичлэгийн төрөл зүйлийн хувьсал хөгжил нь энгийнээс хүнд руу, нэгжээс ерөнхий рүү шилжих зүй тогтлын дагуу явж ирснийг бид харгалзан үзэх шаардлагатай юм. Тодруулж хэлбэл сонин хэвлэл анх үүсэх үед ажиглалтын аргаар олж авсан баримтуудыг мэдээлэх зорилготой энгийн, жижиг бичлэгийн төрлүүд бий болж, аажим аажмаар үйл явдлыг газар дээрээс нь сурвалжлан хүргэдэг, баримтуудын дотоод мөн чанарт нэвтэрч нэмэлт мэдээллийн тусламжтайгаар тайлбарлаж, үнэлэлт дүгнэлт өгдөг сурвалжлага, өгүүлэл, тэмдэглэл зэрэг төрлүүд үүсч, үргэлж баяжин хөгжиж, боловсронгуй болсоор ирсэн түүхтэй ажээ. Цаашид ч ийм замаар хөгжих нь тодорхой.

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд сэтгүүл зүй байгаа цагт бичлэгийн төрөл байх болно. Бичлэгийн төрөл гэдэг нь

өргөн утгаар нь нийтлэл, нэвтрүүлгийн агуулгын хэлбэржсэн илэрхийлэл учир бодит байдлын аливаа үзэгдэл, үйл явдал, баримтыг бичлэгийн хэлбэрээр дамжуулан олон нийтэд хүргэж ирсэн, цаашид ч хүргэх болно. Тиймээс бичлэгийн энэхүү хэлбэрийг яаж нэрлэх нь чухал биш, бичлэгийн төрөл зүйл хэмээх ойлголт сэтгүүл зүйн хувьд тогтвортой, мөнхийн ойлголт гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс бичлэгийн төрөл зүйл гэж байдаггүй, яаж бичих нь зохиогчийн эрх, энэ бол коммунист сэтгүүл зүйд байдаг зүйл, чөлөөт хэвлэлд бичлэгийн төрлийн тухай ярих нь утгагүй гэж их мэдэгчийн дүр үзүүлэгчдийн номлол ор үндэсгүй үлгэр гэдэг нь ойлгомжтой. Өнөөдөр Монголын сэтгүүл зүйн бичлэгийн ур чадвар, төрөл зүйлд ийм замбараагүй байдал бий болсон нь шилжилтийн үеийн сэтгүүл зүйд ажиглагддаг нийтлэг үзэгдлийн нэг бөгөөд цаашид аажим аажмаар зөв гольдролд орох нь гарцаагүй.

Бичлэгийн төрлүүдэд ажиглагдаж буй шинэлэг үзэгдлийн нэг бол асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт бичлэгийн зүйлүүдэд зохиогчид маргаан өрнүүлэх, мэтгэлцэх, өөрийн санаа бодлыг бусадтай хуваалцах гэсэн хүсэл эрмэлзэл нэмэгдсэн явдал юм. Энэ бол ардчилсан, иргэний нийгэмд үнэнийг олох цорын ганц зам болох олон ургальч үзэл, ил тод байдал, үгийн эрх чөлөө нэмэгдэж, орчин үед дэлхийн олон оронд нэлээд эрчимтэй хөгжиж буй иргэний сэтгүүл зүй манай оронд идэвхтэй нэвтэрч буйн илрэл юм. Гэхдээ энэ талаарх тухайн редакцийн байр суурь, нийтлэлийн бодлого нь тодорхой байх ёстой. Өөрөөр хэлбэл өдөр тутмын

шуурхай мэдээлэл ба зохиогчийн үзэл бодол, мэдээллийн бичлэгийн төрөл ба редакцийн өгүүлэл, шүүмж, асуудал дэвшүүлсэн өгүүллийн зааг ялгааг тодорхой болгож, тэднийг сонин хэвлэлд байрлуулах, нэвтрүүлгийн хөтөлбөрт оруулахдаа хамгийн оновчтой хувилбарыг сонгох нь чухал юм. Өнөөдөр манай зарим ХМХ энэ асуудалд хайнга хандаж, оновчтой өгч чадахгүй байгаагаас үзэл бодол хэт давамгайлж, Монголд үзэл бодлын сэтгүүл зүй ноёрхож эхэлсэн гэж шүүмжлэх болсон. Олон ургальч үзлийг эрхэмлэн дээдэлдэг, чөлөөт хэвлэл хэвийн үзэгдэл болсон аль ч орны сэтгүүл зүйд маргаан, мэтгэлцээн өрнүүлэх, санал бодлоо хуваалцах, бусдын үгийг сонсох, олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөхөд чиглэгдсэн нийтлэл, нэвтрүүлэг элбэг байдаг нь жирийн үзэгдэл. Асуудлын гол нь түүнийг яаж, ямар арга хэлбэрээр олон түмэнд хүргэх вэ гэдэгт оршино.

Өөр нэг зориуд тэмдэглэж хэлэх зүйл бол бичлэгийн төрлүүдийн хэл найруулгад томоохон өөрчлөлт гарсан явдал юм. Хэдийгээр энэ бол монгол хэлний найруулга зүй судлаачдын судлагдахуун боловч сэтгүүл зүй судлаач хүний хувьд өөрийн санал бодлоо цухас дурдъя. Ерөнхийдөө бүх ХМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга эрс муудсан. Уран сайхны элемент, уянгын халил багасч, нийтлэлийн өнгө аяс давамгайлж, урт хавсарсан нийлмэл өгүүлбэр голлох болсон. Хэт чөлөөтэй бичих нэрийн дор сонгож авсан сэдвийг гадна талаас нь өнгөцхөн тоочих, мэргэжлийн үг хэллэг, гадаад нэр томъёог шохоорхох, хэмжээнээс хэтэрсэн үнэлэлт дүгнэлт өгч мэдэмхийрэх хандлага газар авсан. Үүнийг мэдээллийн шуурхай бай-

дал, мэдээллийн багтаамжийг дээшлүүлэх асуудалтай холбон тайлбарладаг нь үндэслэл муутай, зөвхөн өөрийн алдаа дутагдлыг хаацайлгах гэсэн оролдлого юм. Английн нэрт зохиолч Вальтер Скотт: "Түргэн бичигчийн эмгэнэлт онцлог нь тэд ерөөс товч бичиж чаддаггүй" гэж хэлсэн нь өнөөдрийн Монголын сэтгүүл зүйн бичлэгийн бодит дүр зургийг илэрхийлж буй мэт. Бичлэгийн чанар эрс муудсаны гол шалтгаан нь нэг талаар редакцийн газрын дотоод хяналт үгүй болж, нөгөө талаар залуу сэтгүүлчдийн монгол хэлний мэдлэг тун тааруу байгаатай холбоотой юм. Үүнийг ерөнхий боловсролын сургуулиудын өгч байгаа суурь мэдлэгтэй ч холбон тайлбарлаж болно. Нийтлэл, нэвтрүүлгийн бичлэгийн чанарыг сайжруулах хамгийн гол арга зам бол сэтгүүлч боловсон хүчнийг ажилдаа авахдаа монгол хэлний шалгалтыг заавал авах, туршилтын хугацаанд монгол хэлний найруулга зүйн мэдлэг, чадварыг гол шалгуур болгон үзэх, монгол хэлний давтан бэлтгэх сургалтанд хамруулах, бичсэн нийтлэлүүдэд мэргэжлийн хүмүүсээр дүн шинжилгээ хийлгэх ажлыг тогтмолжуулах, мөн анхаарал хандуулах ёстой дараагийн гол асуудал бол их, дээд сургуульд орох орчин цагийн монгол хэл, найруулга зүй, редакторлах арга зүй, практик сэтгүүл зүй зэрэг хичээлүүдийн цагийг нэмэх явдал юм. Дээрх асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр ХМХ-үүдийн нийтлэл, нэвтрүүлгүүдийн хэл найруулгыг сайжруулах боломжгүй.

Ишлэл

¹ Григорян М. 2007. Пособие по журналистике. М., с. 15.

² Зулькафиль М., Чойсамба Ч. 2007. Америкийн сэтгүүл зүй. УБ., номыг үзнэ үү.

³ Баасансүрэн Т. 2008. "Үнэн" сонинд нийтлэгдсэн Монголын шилдэг зарим нийтлэлд хийсэн зурвасхан ажиглалт // "Сэтгүүл зүй" МУИС-ийн ЭШБ. №307 (09), 29-30 дахь тал.

⁴ Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар дэвтэр. УБ., 293 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009, 2010. Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил. 4, 5-р боть. УБ.
2. Григорян М. 2007. Пособие по журналистике. М.
3. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
4. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар (1,2-р дэвтэр), УБ.
5. Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.
6. Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.
7. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.
8. Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар боть. УБ.
9. Цэвлээ Х. 2004. "Миний" сэтгүүл зүй. УБ.

Резюме

В данной статье анализируется особенности и тенденции развития жанров публикаций и передач современных СМИ Монголии на примерах ежедневных газет, Национального общественного телевидения и радио, а также коммерческих телевидений. Также в статье автор подробно останавливается на основных факторах, влияющих на трансформацию жанров и качество газетных публикаций, теле- и радиопередач, и даёт некоторые практические рекомендации об улучшении качества и мастерства материалов СМИ.